ВИДЕО ШТОРК · 2022 оны 5-р сарын 3

ЦЭЦЭРЛЭГИЙН ОРЧИНД ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ, БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЬЕ!



Прокурорын байгууллагаас "Хүүхдийн эрх" нэгдсэн аяныг "Хүүхэд бүрийн төлөө" уриан дор зохион байгуулж байгаа билээ. Энэ ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн прокурорын газраас тус дүүргийн боловсролын хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран "Цэцэрлэгийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, болзошгүй эрсдэлээс сэргийлье" сургалтыг дүүргийн нутаг дэвсгэрт сургуулийн өмнөх боловсрол олгож буй цэцэрлэгийн эрхлэгч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнуудын дунд зохион байгууллаа.

Сургалтын үеэр Чингэлтэй дүүргийн прокурорын газраас "Бага насны хүүхдийн эсрэг гэмт хэрэг"-ээс урьдчилан сэргийлэх, Чингэлтэй дүүргийн боловсролын хэлтсээс "Сургуулийн өмнөх боловсролын байгууллага дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх", Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсээс "Бага насны хүүхэдтэй ажиллах арга зүй" сэдвээр тус тус мэдээлэл хийж оролцлоо.

Сургалтад нийт 37 цэцэрлэгийн эрхлэгч, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнууд хамрагдаж цаашид Сургуулийн өмнөх боловсрол олгох байгууллага дахь хүүхэд хамгааллын асуудлыг хэрхэн хэрэгжүүлэн ажиллах талаар санал солилцсон

байна.

Видео: https://www.youtube.com/watch?v=xS0RyA1TNfQ

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2125